



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/267

Мандалговь

Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд
штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1, 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдтай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.5 дах заалт, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймгийн Дэлгэрцогт сумд "Гамшгаас хамгаалах иж бүрэн", Адаацаг, Хулд сумдад "Гамшгаас хамгаалах команд штаб"-ын сургууль, Дэрэн, Сайнцагаан, Луус сумдад "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс 9 дүгээр сарын 29-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

Хоёр. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэгийг чанартай зохион байгуулж дүнг танилцуулахыг Онцгой байдлын газар (хурандаа М.Адъяабаатар)-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх сургуулиудыг зохион байгуулахад шаардагдах зардал 3.015.000 (гурван сая арван таван мянган) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010730

Аймгийн Засан даргын 2020 оны 09 дүгээр
сарын 22-ны өдрийн 1/сз дугаар
захирамжийн хавсралт

СУРГУУЛЬ, ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Бичиг хэргийн зардал					
1	Газрын зураг	ш	3	50.000	150.000
2	Бичгийн цаас	Боодол	2	12.000	24000
3	Ватум цаас	ш	20	1.000	20.000
4	шугам	ш	10	1.500	15.000
5	Өнгийн будаг	ш	10	5.500	55.000
6	Гортиг	ш	10	3.000	30.000
7	Харандаа	ш	10	800	8.000
8	баллуур	ш	10	500	5.000
9	тодруулагч	ш	10	1.000	10.000
10	Тооны машин	ш	5	8.000	40.000
11	Үдээсний машин	ш	5	6.000	30.000
12	Үдээс	Хайрцаг	5	6.000	30.000
13	Цаасны цавуу	ш	10	1.500	15.000
14	Самбар	ш	2	150.000	300.000
15	Цаасны хутга	ш	5	1.500	7.500
16	Хавтас	ш	10	3.000	30.000
17	Бал /өнгийн/	ш	10	1.500	15.000
18	макер	ш	10	1.000	10.000
19	Принтерний хор	ш	2	45.000	90.000
Бичиг хэргийн зардалд					869.000
Томилолтын зардал					
1	Сургуулийн удирдагч	Хоног	12	12.000	144.000
2	Штабын дарга	Хоног	12	12.000	144.000
3	Дундын хянагч	Хоног	12	12.000	144.000
4	Дундын хянагч	Хоног	12	12.000	144.000
5	Жолооч	Хоног	12	12.000	144.000
Нийт					720.000
Шатахууны зардал					
1	АИ-92	литр	100	1540	154.000
Шатахууны зардал					154.000
Тараах материал					
1	Гал түймэр	Ш	600	530	318.000
2	Газар хөдлөлт	Ш	600	530	318.000
3	Үерийн аюул	Ш	600	530	318.000
4	Ахуйн осол	Ш	600	530	318.000
Тараах материалын зардалд					1.272.000
Нийт					3.015.000